



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Өмчлөх эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1, 43 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 218 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 341 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдааны тэмдэглэл, Монгол Улсын иргэн Лхагважав овогтой Баянмөнхтэй байгуулсан 06/19 дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”-ний 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянхонгор сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлалтай, 1975 онд ашиглалтад орсон, 80 м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг худалдах 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн нээлттэй дуудлагын худалдааны ялагч Л.Баянмөнх нь дэнчин 2,972,800.00 /Хоёр сая есөн зуун далан хоёр мянга найман зуу/ төгрөг, үлдэгдэл төлбөр 99,752,000 /Ерэн есөн сая долоон зуун тавин хоёр мянга/ төгрөг, нийт үнэ 102,724,800.00 /Нэг зуун хоёр сая долоон зуун хорин дөрвөн мянга найман зуу/ төгрөгийг хууль болон гэрээнд заасан хугацаанд бүрэн төлсөн тул иргэн Лхагважав овогтой Баянмөнхөд дээрх үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Иргэн Л.Баянмөнхөд өмчлөх эрхийн гэрчилгээ олгохыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний хөлс 500,000.00 /Таван зуун мянга/ төгрөгийг “Хөрөнгийн үнэлгээний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Баянхонгор аймаг дахь салбарын үнэлгээчин Д.Энхтуяад хувьчлалын орлогоос шилжүүлэхийг ахлах нягтлан бодогч Ж.Мөнхтүвшинд зөвшөөрсүгэй.

4. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжсэнтэй холбогдуулан үндсэн хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэхийг Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст зөвшөөрсүгэй.

5. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянхонгор сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлалтай үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, батлуулахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Эрэвгийлхамд даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



D:\Huraldaanii material\2019 on\2019.10.29 №21.docx

0000031